

Хялбаршуулсан Дүрвэгсдийн процедур

Та аюулгүй орноос юм уу эсвэл
Европийн холбооны улсын аль нэг
гишүүн орноос олон улсын
хамгаалалт хүссэн тохиолдолд

Танд яагаад энэ товхимлыг өгч байна вэ?

Та Нидерландын Вант улсад орогнох хүсэлт тавихыг хүсч байна. Орогнол гэдэг нь: хамгаалалт хүсч байгаа ба энэ нь нутагтаа аюулгүй байх боломжгүй, мөн тэндээ ямар ч хамгаалт авч чадахгүй хүмүүст зориулсан.

Хэрэв та орогнол хүсвэл Нидерландын төр засгаас энд оршин суух эрхийн бичиг асууж байна гэсэн үг юм. Танд энэ эрхийн бичиг нь Нидерландын Вант Улсад ажиллаж амьдрахад хэрэгтэй болно. Та орогнол хүссэний дараа таны дүрвэгсдийн процедур тань эхлэнэ.

Нидерландын Засгийн газар танд оршин суух эрх авах эсэхийг үнэлэхийн тулд хуулын зүйн явцын дагуу шийддэг.

Та энэ товхимлоос дүрвэгсдийн орогнол хүссэн процедур ямар байдалтай явагдах болохыг уншина. Та эндээс мөн юу хийх ёстойгоо болон танаас ямар зүйлс шаардаж байгаагаас гадна (таны үүрэг) Нидерланд улсын зүгээс танд ямар эрх өгч байгааг унших болно.

Та ямар тохиолдолд орогногчийн оршин суух эрх авч болох вэ?

Нидерландын Вант улсын гадаадын иргэдийн хуулинд ямар тохиолдолд орогногчийн оршин суух эрх авч болох болзлууд нь бичигдсэн байдаг. Та оршин суух эрх авч чадна.

Хэрэв:

- Та арьс өнгө, шашин шүтлэг, язгуур угсаа, улс төрийн үзэл бодол, иргэншлэл ба нийгмийн ямар нэгэн бүлэглэлд хамаарагдагаас болоод нутагтаа байж болохооргүй хангалттай үндэслэл байгаа учраас амь насанд тань ноцтой аюул учирч буй тохиолдолд
- Танд цаазаар авах ял өгсөн юм уу эрүүдэн шүүгдэх, хүнлэг бус болсон доромжилсон байдлаар тантай харьцах байдлаас болоод нутагтаа байж болохооргүй хангалттай үндэслэл байгаа тохиолдолд
- Та эх орондоо ямар нэг хүчирхийллийн золиос болох эсвэл зэвсэгт мөргөлдөөний золиос болно гэж айсанаас болоод нутагтаа байж болохооргүй хангалттай үндэслэл байгаа тохиолдолд
- Таны нөхөр / эхнэр, хамтрагч, эцэг эх, насанд хүрээгүй хүүхэд саяхан Нидерландад орогнох оршин суух зөвшөөрөл авсан тохиолдолд.

Та аюулгүй орноос юм уу эсвэл Европийн холбооны улсын аль нэг гишүүн орноос олон улсын хамгаалалт хүссэн бол ИНД таныг энд дурдсан болзлуудыг хангахгүй байна гэж үзэх үндэслэл өндөр байна. Тиймээс таны орогнол хүссэн хүсэлтийг хялбар ба түргэвчилсэн хугацаанд шийдвэрлэнэ.

Аюулгүй орнуудын жагсаалт

Албани, Алжир, Андорра, Австрали, Бельги, Босни ба Герцеговина, Бразил, Болгар, Канад, Кипр, Дани, Герман, Эстони, Финлянд, Франц, Гүрж, Гана, Грек, Унгар, Ирланд, Энэтхэг, Итали, Ямайка, Япон, Косово, Хорват, Латви, Лихтенштейн, Литва, Люксембург, Македон, Мальта, Марокко, Монако, Монгол, Монтенегро, Нидерланд, Шинэ Зеланд, Норвеги, Украин, Австри, Польш, Португал, Румын, Сан Марино, Сенегал, Серби, Словени, Словак, Испани, Того, Тринидад ба Тобаго, Чех, Тунис, Ватикан, Их Британи, Америкийн Нэгдсэн Улс, Исланд, Швед, Швейцарь улсууд орно.

Энэ жагсаалт өөрчлөгдөх боломжтой: улс орнууд нэмэгдэх болон хасагдах боломжтой. Энэ нь тухайн улсын аюулгүй байдлаас хамаарна.

Хувь хүний мэдээллийн боловсруулалт

Хувь хүний мэдээлэл бол таны талаарх бүх төрлийн мэдээлэл юм. Энэ товхимолын доор бидэнтэй хамтран ажиллаж буй байгууллагуудын нэрсүүд байгаа. Эдгээр байгууллагууд таны цагаачлалын өргөдөл, мэдэгдэл эсвэл хүсэлтийг боловсруулах явцдаа таны хувийн мэдээллийг ашигладаг. Танаас тэд таны мэдээллийг асуугаад хэрвээ шаардлагатай бол бусад байгууллагууд, хүмүүсээс таны талаархи мэдээллийн талаар лавладаг. Эдгээр байгууллагууд таны өгөгдлийг ашиглаад, хадгалж, хуулийн дагуу шаардлагатай бол бусад байгууллагуудад мэдээллийг дамжуулдаг. Хувь хүний нууцлалын тухай хууль тогтоомжинд таны өгөгдлийг боловсруулдаг байгууллагуудын дагах ёстой үүргүүдийг заасан байдаг. Жишээлбэл, тэд таны өгөгдлийг анхааралтай, аюулгүйгээр боловсруулах ёстой. Хувь хүний нууцлалын тухай хуулинд мөн таны эрхийн талаар заасан байдаг, тухайлбал:

- Байгууллагуудаас өөрийн мэдээллийн талаар асууж мэдэх;
- Байгууллагууд таны өгөгдлөөр юу хийдэг, яагаад таны өгөгдлийг хуримтлуулж байгаа гэдгийг мэдэх;
- Цаашлаад ямар байгууллагуудад таны мэдээллийг дамжуулж өгч байгааг мэдэх эрхтэй.

Та өөрийн хувийн мэдээллийн боловсруулалт болон өөрийн эрхийн талаар илүү ихийг мэдэхийг хүсч байна уу? Тэгвэл тухайн байгууллагуудын вэбсайтуудыг судлана уу. Энэ товхимлын доод хэсэгт та тэдгээр байгууллагуудын вэб хаягуудыг олж болно.

Та ямар байгууллагын хүмүүстэй уулзах вэ?



COA Centraal Orgaan opvang asielzoekers

Centraal Orgaan opvang asielzoekers (COA) – Дүрвэгсдийг Хүлээн Авах Төв Байгууллага (COA) нь Нидерландын Вант улс дахь дүрвэгсдийг хүлээн авах ба үүнтэй холбоотой асуудлуудыг хариуцдаг. COA таныг хоол, байраар хангах ба эрүүл мэндийн зардлын даатгалтай болоход тусалдаг. Та эмчтэй холбогдож тусламж авахаар бол COA-д хандаж болно. COA бол биеэ даасан байгууллага ба таны дүрвэгчийн асуудлыг шийдэхгүй.



VluchtelingenWerk Nederland – Нидерланд дахь Цагаачийн тусламжийн байгууллага нь биеэ даасан хүмүүнлэгийн байгууллага ба цагаач, дүрвэгсдийн эрх ашгийг хамгаалах зорилготой юм. Цагаачдын тусламжийн байгууллага нь дүрвэгсэдэд мэдээлэл өгөх болон цагаачдыг хүлээн авах явцын талаар тайлбар өгдөг. Цагаачдын тусламжийн байгууллага нь танд мэдээлэл өгөхөөс гадна цагаачийн явц тань явагдаж байх үед дэмжлэг үзүүлэх мөн бусад байгууллагатай асуудалтай бол таны өмнөөс энэ байгууллагуудтай зуучилж өгдөг. Тэд таны өмгөөлөгчтэй нягт хамтран ажилладаг. Мөн Цагаачдын тусламжийн байгууллага нь цагаачаар орох хүсэлтийн хариуг тань шийддэггүй.

Raad voor Rechtsbijstand *legal aid*

Raad voor Rechtsbijstand – Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар таныг өмгөөлөгчийн тусламж аваад зардлыг нь төлж чадахгүй тохиолдолд тусалдаг. Өмгөөлөгчийн танд үзүүлсэн үйлчилгээний хөлсийг Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар өмгөөлөгчид төлдөг. Өмгөөлөгч бол Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газрын ажилтан биш юм. Өмгөөлөгч бол таны дүрвэгсдийн процедурт туслалцаа үзүүлэх биеэ даасан хууль эрх зүйн тусламж үзүүлэгч юм.



Immigratie- en Naturalisatiedienst
Ministerie van Veiligheid en Justitie

Immigratie- en Naturalisatiedienst (IND) – Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага (ИНД) нь Нидерландын Вант улсын Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яамны харъяа байгууллага юм. IND-гийн ажилчид таныг хэн болох, таны иргэншил харъяалал, ирэхдээ туулсан зам, эх орноосоо дүрвэн гарсан шалтгааны тухай таньтай ярилцдаг. Тэгээд тэд таны хувийн түүхийг болон эх орны тань нөхцөл байдлыг судалдаг. Дараа нь тэд таныг Нидерландын Вант улсад (түр хугацаанд) үлдэж болох эсвэл эх орондоо буцах ёстой эсэхийг шийдвэрлэдэг.



IND ба COA-гийн хүлээн авах төвийн барилгуудад **хамгаалагч** нар байдаг. Та тэднийг дүрэмт хувцсаар

нь таньж болно. Тэд таны аюулгүй байдлыг хангадаг. Та тэднээс IND ба COA-гийн барилгуудад болон талбайд ямар зүйлс зөвшөөрөгдсөн болон хориотой байдгийг асууж болно. Эдгээр хамгаалагчид таны дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэхэд нөлөө үзүүлэхгүй.



Dienst Terugkeer en Vertrek
Ministerie van Veiligheid en Justitie

Dienst Terugkeer en Vertrek (DT&V) – Хууль Зүйн Яам ба Батлан Хамгаалахын харъяа Буцаах алба (DT&V) байгууллага нь таныг буцаж үйл ажиллагаагаа зохион байгуулахад тань тусалдаг. Хэрвээ IND таны дүрвэгсдийн өргөдөлд татгалзсан бол DT&V -гийн ажилтанууд бие даан нутаг буцаж явах асуудалд тань дэмжлэг үзүүлдэг. Хэрэв та бие даан Нидерланд улсыг орхиж яваагүй тохиолдолд DT&V таныг хүчээр нутаг буцаадаг.



Afdeling Vreemdelingenpolitie, Identificatie en Mensenhandel (AVIM) –

Гадаад иргэдийг хариуцсан цагдаагийн алба, биеийн байцаалтыг тодорхойлох ба хүний наймааг хариуцах алба (AVIM) нь үндэсний цагдаагийн албаны нэг хэсэг юм. AVIM нь таныг хэн болохыг тодорхойлж биеийн байцаалтыг тань бүртгэх үүрэгтэй. Үүний тулд тэд таны ачаа тээшийг шалгах, биенд нэгжлэг хийж болно, таны хувийн мэдээлэл болон баримт бичгийг асууж, таны зураг болон хурууны хээг авдаг. Үүнээс гадна AVIM таны аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.



Internationale Organisatie voor Migratie (IOM) –

Олон Улсын Дүрвэгсдийн Төлөөх Байгууллага (IOM) – бол биеэ даасан дэлхий даяар дүрвэгсэдэд тусалдаг байгууллага юм. IOM таныг өөрөө сайн дураараа Нидерландын Вант улсыг орхин гарах бол тусалж чадна. IOM таныг буцахад болон дахин эх орондоо эргэн зохицоход тань хэрэгтэй бодит мэдээллийг өгч Нидерландын Вант улсаас явах бэлтгэлээ хангахад тань тусалдаг. Та мөн VluchtelingenWerk – (Дүрвэгчдийн Ажил) байгууллага эсвэл өмгөөлөгчөөсөө тусламж гуйж болно.

Танаас юу хүсдэг вэ?

Дүрвэгсдийг хүлээн авах явцад та яагаад орогнох хүсэлт тавьж байгаа шалтгаанаа хэлдэг. Танд хамгаалалт хэрэгтэй гэдгээ та дэлгэрэнгүй тайлбарлах нь маш чухал. Мөн та өгч буй мэдэгдэлээ баталгаажуулахын тулд баримт бичгүүдийг ИНД-д өгөх ёстой. Жишээлбэл иргэний бичиг баримтууд юм уу захианууд.



ИНД-гийн хувьд танд анхаарч үзэх ямар нэгэн хувийн нөхцөл байдал бий юу? Үүнийгээ та Дүрвэгсдийн тусламжийн байгууллагат юм уу ИНД-д ярилцлага өгч байх үедээ мэдэгдэх хэрэгтэй. Энэ тохиолдолд ИНД ярилцлагаа өгч байх үед тань юм уу СОА-гийн дүрвэгсдийн байранд байх үед тань арга хэмжээ авч чаддаг. ИНД таны хувийн асуудалд тань аль болох тусламж дэмжлэг үзүүлэхээр хичээх болно.

Дүрвэгсдийг хүлээн авах явц алхам алхамаар

Дүрвэгсдийг хүлээн авах явцын бүх үе шатуудыг энэ доор бичив. Та Нидерланд улсын засгийн газрын бодлогын дагуу аюулгүй орноос ирсэн учраас ИНД таны дүрвэгчээр ороход тавьсан хүсэлтийг тань хялбаршуулсан Дүрвэгсдийг хүлээн авах процедурт оруулна.

Дүрвэгсдийг хүлээн авах процедур явагдаж байх үед та процедуртаа бэлтгэж байхдаа байрлаж байсан тэр дүрвэгсдийг хүлээн авах газартаа байрласан хэвээр байх болно. ИНД-гийн ярилцлагууд нь ИНД-гийн албан контоорт явагдана.

Та энэ доор таны дүрвэгчийн процедур ямар байдалтай явагдах болохыг уншина.



1 дүгээр үе: ИНД-д бүртгүүлэх.

Та Тэр Апэл-ийн ИНД -д ирснээ мэдүүлнэ. ИНД -гийн ажилтад таныг бүртгэж авсаны дараа дүрвэгсдийн орогнох хүсэлтээ тавихын тулд хэсэг хугацаанд хүлээнэ.

2 дугаар үе: Бүртгүүлэх хүснэгт

Та бүртгүүлэх хүснэгтэд өөрийн талаарх мэдээллийг бөглөсөн байна. Энэхүү хүснэгтийн мэдээлэлд тулгуурлан ИНД таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг үргэлжлүүлэн шийдвэрлэдэг.

3 дугаар үе: Гадаад Иргэдийн Цагдаагийн албанд биеийн байцаалтаа бүртгүүлэх/бүртгүүлэх (АВИМ)

Та мөн Гадаад Иргэдийн цагдаагийн газарт бүртгүүлсэн байна. Тэд таныг тодорхойлж бүртгэж авах ба та тэдэнд дүрвэгчээр орох хүсэлтэд гарын үсэг зурна. Ингэснээр ИНД таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг хүлээн авч чадна.

4 дүгээр үе: ИНД таны дүрвэгсдийн процедурыг тодорхойлно

ИНД 1, 2, 3 дугаар үе шатуудын мэдээллийг үндэслэн ямар дүрвэгсдийн процедураар таны өрөгдөл цаашид явагдахыг тогтоох болно. Таны орогнох хүсэлтийг шалгаж байх явцад таныг өөр процедураар шалгах шаардлага гарч болзошгүй. Энэ үед таны процедур солигдоно. Энэ тохиолдолд танд шинэ товхимол өгөх ба үүнд бүх үеүүдийг нэг бүрчлэн тайлбарласан байна.

Хэрвээ та Хялбаршуулсан дүрвэгсдийн процедурт хамрагдсан хэвээрээ байгаа бол танд Дүрвэгсдийн Ажил байгууллагын ажилтан таны процедурын талаар тайлбарлаж өгнө. Өмгөөлөгч таныг ИНД-д өгөх ярилцлагад үнэгүй бэлдэж мөн танд хуулийн талаар үнэгүй зөвлөгөө өгнө.

5 дугаар үе: ИНД-гийн ярилцлаганд орох

ИНД-гийн ажилтан тантай нэг л удаа та хэн болох, таны иргэншлэл, та яаж явж ирсэн замын маршрутын талаар ярилцлага авна. Энэ ярилцлагыг

сонсох ярилцлага гэж хэлдэг. Хэрэв та аюулгүй орноос ирсэн бол мөн танаас энэ сонсох ярилцлага дээр та ямар шалтаануудаас болоод дүрвэгчээр орох хүсэлт тавьж байгааг асуудаг. Хэрэв та хүсвэл Дүрвэгсдийн Ажил байгууллагын ажилтныг сонсох ярилцлагадаа хамт байлгах асууж болно. Хэрвээ боломжтой бол Дүрвэгсдийн Ажил байгууллагын ажилтан таны сонсох ярилцлагад хамт байх болно.

Та сонсох ярилцлагадаа боломжийнхоо хэрээр сайн бэлдээрэй. Танд нэг л удаа хэн болохоо тайлбарлан хэлэх боломжийг олгодог. Та үргэлж үнэн зөв мэдээлэлийг өг, та хуурамч (аялалын) бичиг баримт дахь мэдээлэлийг өгч болохгүй. Мөн та хэзээ өөр нэр (=нууц нэр) хэргэлж байснаа хэл. Таны бичиг баримтууд болон тодорхойлсон зүйлсийг жинхэнэ мөн үү гэж шалгадаг. Хэрэв ИНД таны тодорхойлсон зүйлс болон бичиг баримтууд хурамч гэж дүгнэлт гаргасан тохиолдолд таны дүрвэгчээр орох хүсэлтэд муугаар нөлөөлдөг.

Танд хамгаалалт хэрэгтэй байгаа гэдэг нь таны хэлсэн бүх зүйлд тодорхой байх нь чухал. Танд юу тохиолдсон ба ямар зүйлээс болж та нутагтаа хамгаалалт авч чадаагүй шалтгаанаа үнэн зөв, бүрэн бүтэн, ойлгомжтой ярь. Хэрэв та ямар нэг өнгөрсөн явдлаа тодорхой санахгүй байгаа бол үүнийгээ ИНД-гийн ажилтанд мэдэгд. ИНД-гийн ажилтан танай орны ерөнхий байдлыг мэдэж буй. Тиймээс та өөрийхөө байдлын талаар ярих тань чухал. Ямар учраас танд хамгаалалт хэрэгтэй юм. Аль болох шаардлага бүхий чухал зүйлсээ бүгдийн нь хэл. Хэрэв танд дүрвэх болсон шалтаануудаас болоод сорив, биеийн болон сэтгэцийн зовиур шаналгаа байвал үүнийгээ ИНД-гийн ажилтанд хэлэх нь чухал. Энэ тохиолдолд ИНД танд шүүх эмнэлгийн шинжилгээ хийж өгч чадна. Мөн та энэ шинжилгээг хувиараа өөрөө мөнгөө төлөөд хийлгэж болно.

ИНД-гийн ярилцлагуудад хэлмэрч байлцана. ИНД-гийн ажилтан асуултуудаа Нидерланд хэл дээр төвина. Хэлмэрч энэ асуултуудыг таны ойлгодог хэл дээр орчуулж өгнө. Хэлмэрч таны хариултуудыг Нидерланд хэл дээр орчуулж өгнө. Хэлмэрч бие даасан ба таны орогнох хүсэлтийн талаарх шийдвэрт тань ямар ч холбогдолгүй байдаг. Хэрвээ хэлмэрч та хоёр бие биенээ сайн ойлголцохгүй байгаа бол та хурдхан мэдэгдээрэй. ИНД өөр хэлмэрч хайж олохыг хичээнэ. Та асуултуудыг ойлгоогүйгээс болоод буруу ойлголцохгүй байх нь нэн чухал.

Хэрэв та эхнэр/ нөхөртэйгөө цугтаа орогнох хүсэлт тавьсан тохиолдолд ИНД-гийн ажилтан та хоёроос тус тусад нь сонсох ярилцлага авах болно. Хэрэв та

15-аас дээш насны хүүхдүүдтэй бол тэднээс бас тусад нь сонсох ярилцлага авна. Танд урьд нь өгсөн тэр өмгөөлөгчөөсөө та сонсох ярилцлагынхаа тайлангийн нэг хувийг хүлээж авах болно.

6 дугаар үе: Дүрвэгсдийн орогнох өргөдлийг тань шийдэх

ИНД таны хавтаст материалыг шалган үзэхдээ та орогногчийн оршин суух эрх авах болзолуудыг бүрдүүлж байна үү гэдгийг харна. Энэ шийдвэрээс гарсан үзүүлэлтээс хамааран таны дүрвэгсдийн процедур цаашид ямар байдлаар үргэлжлэх нь шалтгаална. Хоёр боломжууд гарч ирнэ.

1. Таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийн хариуг тогтоохын тулд ИНД-д судалгаа хийх илүү хугацаа шаарлагатай болно. ИНД таны орогнох хүсэлтийг тань Ерөнхий Дүрвэгсдийн процедурт оруулна. Энэ тохиолдолд танд өөр товхимол өгөх ба үүнд Ерөнхий Дүрвэгсдийн процедурын талаар тайлбарласан байна.
2. ИНД таныг орогногчийн оршин суух эрх авах болзолуудыг хангахгүй байна гэж үзнэ. Та өмгөөлөгчөөрөө дамжуулан ИНД-ээс нэг захиа хүлээн авах (=урьдчилсан шийдвэр) ба үүнд ИНД дүрвэгчийн орогнол хүссэн өргөдлийг тань татгалзах төлөвлөгөөтэй байгаагаа илэрхийлсэн байна. Энэ захианд урьдчилж гаргасан татгалзсан хариуны шалтгаанууд байх ба энэ нь танд ямар нөлөө үзүүлэх талаар бас бичээстэй байна. Таны өмгөөлөгч тантай энэ захианы талаар ярилцана. Энэ захидалд мөн таны эсрэг хилийн хорио тогтоогдсоныг дурдсан байх боломжтой.

Энэ нь таныг хорионд заасан хугацаанд Европын холбооны орнуудад байх болон хилээр нь нэвтрэн орохыг хориглоно гэсэн утгатай юм. Хилээр нэвтрэн орох хориог зөрчихөд хуулийн хуриуцлага хүлээлгэдэг. Зөвхөн насанд хүрсэн дүрвэгч этгээд л хилээр нэвтрэн орох хориог хүлээн авдаг.

7 дугаар үе: Засалт ба нэмэлтүүд + санал бодол

Хэрэв ИНД дүрвэгчийн орогнол хүссэн өргөдөлд тань татгалзах төлөвлөгөөтэй байгаа бол та урьдчилсан шийдвэрээ өмгөөлөгчтэйгээ ярилцана. Таны өмгөөлөгч энэ талаар тантай уулзах цаг авсан байна. Таны өмгөөлөгч ИНД-рүү бичгээр санал бодлоо илэрхийлж чадна. ИНД-ийн урьдчилсан шийдвэрт та энэ захиагаар дамжуулан хариугаа өгч буй. Энэ санал бодлоо илэрхийлсэн захиандаа та ямар учраас ИНД-тэй санаа нэг бус буйгаа илэрхийлнэ. Таны өмгөөлөгч тантай мөн сонсох ярилцлагынхаа тайлангийн талаар ярилцана.

Хэлмэрч мөн таны өмгөөлөгчтэйгээ ярьж буй ярилцлагыг орчуулж өгнө. Хэрэв таны тайланд ямар нэг алдаа юм уу, ямар нэг зүйл орхигдож бичигдсэн байвал таны өмгөөлөгч үүнийг ИНД-д дамжуулна. Сонсох ярилцлагынхаа тайлангаас үүдэн гарсан урьдчилсан шийдвэрийн эсрэг бичиж буй санал бодлоо илэрхийлсэн захиандаа засаж ба нэмж бичих зүйлээ оруулан ИНД-д хоёр хоногийн дотор өгөх хэрэгтэй.

8 дугаар үе: Шийдвэр

ИНД таны санал бодлоо илэрхийлсэн захиаг уншсаны дараа урьдчилсан шийдвэрээ өөрчлөх үү үгүй юу гэдгийг хянаж шалгана. Энэ шийдвэрээс гарсан үзүүлэлтээс хамааран таны дүрвэгчийн процедур цаашид ямар байдлаар үргэлжлэх нь шалтгаална. Та өмгөөлөгчөөрөө дамжуулан ИНД-ээс ямар шийдвэр гарсаныг мэдэх болно. Таны өмгөөлөгч энэ шийдвэрийн утгыг танд тайлбарлана. Хоёр боломжууд гарч ирнэ:

1. Таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд шийдвэр гаргахын тулд ИНД-д судалгаа хийх илүү хугацаа шаарлагатай болно. ИНД таны орогнох хүсэлтийг тань Ерөнхий Дүрвэгсдийн процедурт юм уу эсвэл Уртасгасан Дүрвэгсдийн процедурт оруулах уу гэдгийг шийднэ. Энэ тохиолдолд танд өөр товхимол хуудас өгөх ба үүнд Ерөнхий дүрвэгсдийн процедурын талаар юм уу эсвэл Уртасгасан Дүрвэгсдийн процедурын талаар тайлбарласан байна.
2. ИНД гаргасан шийдвэрээ хэвээр байлгаж таныг дүрвэгчийн орогнол хүссэн оршин суух зөвшөөрөл авах болзлыг хангахгүй байна хэмээн шийдвэрлэнэ. Танд (өмгөөлөгчөөр тань дамжуулан) IND таны дүрвэгчийн орогнол хүссэн өргөдлийн хариуд татгалсан гэж бичсэн (шийдвэр) захиа өгнө. Энэ шийдвэрийн хажуугаар тусад нь хариунаас гарах үр дагаварыг зааж, энэ шийдвэрийн эсрэг авч болох арга хэмжээ мөн буцах боломжуудыг тайлбарласан мэдээлэл өгнө. Энэ шийдвэрт мөн татгалзсан хариуны шалтгааныг дурдаж танд ямар үр дагавар авчиргахыг бичсэн байна. Таны өмгөөлөгч захидлын тухай таньтай хэлэлцэнэ. Энэ захидалд мөн таны эсрэг хилийн хорио тогтоогдсоныг дурдсан байх боломжтой. Хилийн хорио тавигдсан тохиолдолд танд үүний талаар тусгай мэдээлэл өгнө. Энэ хориог мөрдөхийн тулд таны мэдээллийг Шенген орнуудын мэдээллийн системд (SIS) оруулдаг. Энэ нь хорионд заасан хугацаанд таныг Европын холбоонд нэвтэрхийг хориглоно гэсэн утгатай юм.

Дүрвэгсдийн процедурын дараа

Хэрэв ИНД таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд татгалзсан хариу өгсөн бол өмгөөлөгчтэйгөө ярилцан тохироод энэ шийдвэрийн эсрэг Нидерландын шүүхэд хандан давж заалдаж болдог. Үүгээрээ та ИНД-гийн гаргасан шийдвэртэй санал нэг бус байгаагаа шүүгчид мэдэгдэнэ. Та шүүгчээс мөн шүүхэд хандан давж заалдаж байх хугацаандаа Нидерланд улсад хуулийн дагуу байж болох уу гэж асууж болдог. Таны өмгөөлөгч танд энэ талаар туслана. ИНД таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг тань шийдэхдээ Нидерланд улсын хуулийн дагуу шийдсэн байна уу үгүй гэдгийг шүүгч шалгаж судалдаг.

Хэрвээ та аюулгүй орноос ирсэн ба ИНД таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд татгалзсан хариу өгсөн бол таны орон байраар хангагдах эрх дуусч мөн танд энэ улсад байх болон хилээр нь нэвтрэхийг хориглосон хорио тавьдаг. Та Нидерланд улсыг нэн даруйдаа орхин гарах ёстой. Эх оронд нь Буцаах алба (DT&V) таны буцах ажилд танд тусалж чадна. Таныг эрх чөлөө хязгаарласан байранд (VBL) буюу гэр бүлийн байранд (GL) -д байлгах боломжтой. Зөвхөн насанд хүрээгүй хүүхдүүдтэй гэр бүлийг л GL-д байлгадаг. VBL ба GL нь таныг эх орон руу тань буцаах зорилготой байдаг. Эсвэл засгийн газраас таныг албадан гаргах боломжтой бол таныг гадаадын иргэдийг хорих албанд авчирна. Таныг VBL, GL эсвэл гадаадын иргэдийг хорих албанд хүргээгүй бол яах вэ? Энэ тохиолдолд та Нидерланд улсыг өөрийн санаачлагаар орхин явах ёстой. Хэрэв та аюулгүй улс орон луу буцаж байвал ихэнх тохиолдолд танд буцах мөнгө өгдөггүй. Та дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлөө сайн дураараа буцааж татан авсан ч гэсэн танд буцах мөнгө өгдөггүй.

Та нутагруугаа буцаж явах нь таны өөрийн хариуцлага юм. Хэрэв та бие даан Нидерланд улсаас яваагүй тохиолдолд таныг албадан хүчээр/буцаадаг. Хэрэв ИНД таны орогнол хүссэн өргөдлийг татгалзсан тохиолдолд танд DT&V нэг мэдээллийн хуудас өгөх ба энд та нутагруугаа яаж явах талаарх мэдээлэл бичээтэй байдаг. Хэрэв та сайн дураараа нутагруугаа буцаж явъя гэсэн тохиолдолд та Олон улсын Дүрвэгсдийн тусламжийн байгууллагатай холбогдож чадна (IOM). IOM нутаг буцах явах асуудлын талаар бодит мэдээлэл өгч тусалдаг. Та мөн IOM дахь СОА-гийн байранд байрлаж болно. Та мөн Дүрвэгсдийн Ажил байгууллагын ажилтнуудаас болон өмгөөлөгчөөсөө буцаж явах асуудлын талаар асуух юм уу дэмжлэг авч чадна.

Дүрвэгсдийн орогнол хүссэн хүсэлтээ буцаан татах

Та хүссэн үедээ дүрвэгчийн орогнол хүссэн өргөдлөө буцаан татан авч болно. Энэ тохиолдолд таныг өмгөөлөгчтөйгөө, ДүрвэгсдийнАжил байгууллагатай холбогдох юмуу таныг DT&V байгууллагад шууд хандахыг зөвлөдөг. Хэрвээ та орогнол хүссэн өргөдлөө буцаан татан авбал та Нидерландын Вант Улсад байж болохгүй болно. Мөн таны орон байраар хангагдах эрх дуусч энэ улсаас танд энэ улсын хилийг нэвтрэн орох болон энэ улсад үлдэж болохгүй хорио тавих болно. Засгийн газраас танд хилээр нэвтрэн орох хориг тавьж чаддаг. Танд хилээр нэвтрэн орох хориг тавьсан ч гэсэн та дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлөө сайн дураараа татан авсныхаа дараа дахин орогнол асууж болно.

Дүрвэгсдийг хүлээн авах төв юм уу Нидерланд дахь ДүрвэгсдийнАжил байгууллагын ажилтан таныг Эх оронд нь буцаах албаны ажилтантай холбогдуулж өгөх ба та бас өөрөө DT&V-гийн доорх сайтруу <https://www.dienstterugkeerenvertrek.nl/VertrekitNederland/Eigenverantwoordelijkheidvreemdeling/Ikwilterugkeren/index.aspx> ороод энд байгаа нэг тусгай маягт бөглөн захиа явуулж болдог.

DT&V таны Нидерландын Вант улсыг орхиж явах асуудлыг зохицуулахад дэмжлэг үзүүлдэг. Та өөрөө энэ тусламжийг авах эсэх сонголтоо өөрөө хийж болдог. Хэрэв та үүнийг ашиглая гэвэл буцааж явах асуудлыг хариуцсан ажилтан таны эндээс явах асуудлыг тань хэрэгжүүлэх болно. Буцааж явах асуудлыг хариуцсан ажилтан танаас ямар учраас та бие даан явахыг хүсч байгаа талаар тантай ярицах ба Нидерландын Вант улсаас явах боломжуудын талаар хэлэлцэх болно. Үүнд онгоцны билет ба хил давж гарах бичиг баримтууд гэх мэт байна. Түүнчлэн буцааж явах асуудлыг хариуцсан ажилтан та үнэхээр орогнол хүссэн хүсэлтээ буцаан татахыг хүсч байна уу гэдэг талаарх сонголтыг зөв зүйтэй хийх боломжийг олгож өгөхийн тулд таныг ДүрвэгсдийнАжил байгууллага юм уу өмгөөлөгчтэйгээ холбогдон туслалцаа ав гэдэг.

Хэрэв та дүрвэгсдийн процедур үргэлжлэх явцад ямар нэгэн хил давж гарах бичиг баримтгүй бол та өөрийнхөө элчин сайд юм уу консулаас (орлуулсан) хил давж гарах бичгээ өөрөө асуух ёстой. Таны дүрвэгсдийн процедур явагдаж байх энэ явцад DT&V (орлуулсан) хил давж гарах бичгээ асуухад тусламж үзүүлж чаддаггүй.

Түгээмэл асуултууд

Би хэзээ дүрвэгсдийн орогнол хүссэн ярилцлагаа өгөх вэ?

Таныг бүртэж авсны дараа нэн удалгүй танаас ИНД ярилцлага авдаг. Та зөвхөн нэг л ярилцлага ИНД-д өгдөг. Энэ нь бусад дүрвэгсдээс өөр байдаг. Та аюулгүй орноос юм уу эсвэл Европийн холбооны улсын аль нэг гишүүн орноос олон улсын хамгаалалт хүссэн болохоор ИНД таны дүрвэгчээр ороход тавьсан хүсэлтийг тань хурдавчилсан Дүрвэгсдийг хүлээн авах явцаар шийддэг.

Би аюулгүй орноос ирсэн. Яагаад би орогнолын шалтгаанаа ярих IND-ийн ярилцлаганд эхэлж орох болох вэ?

Та аюулгүй улсаас ирсэн учраас танд эхлээд ярилцлагын дуудлага ирэх болно. Мөн таны орогнол хүссэн өргөдөл зөвшөөрөгдөхгүй байх магадлал өндөр байх болно. Ингэснээр орогнол хүссэн, зөвшөөрөл авах боломж өндөртэй дүрвэгсдийг хүлээн авах хангалттай байртай болох юм.

Би дүрвэх болсон түүхээ эмэгтэй хүнд ярих хүсэлтэй байна. Ингэж болох уу?

Нидерландын Вант улсад та өдөр тутмын амьдралд эмэгтэй, эрэгтэй хүмүүстэй аль алинтай нь харьцахаас зайлсхийх аргагүй юм. Нидерландын Вант улсын нийгмийн тогтолцоонд эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш эрхтэй. Таныг энэ эрхийг ч бас хүндлээсэй гэж бид хүсэж байна. Хэрвээ та үнэхээр эмэгтэй IND-гийн ажилтантай илүүтэйгээр дүрвэх болсон түүхээ ярихыг хүсвэл, үүнийгээ бүртгэлийн хуудсандаа тэмдэглээрэй. Эсвэл ДүрвэгсдийнАжил байгууллагад ч бас хүсэлтээ хэлж болно. IND мөн л ярилцлагын үеэр эмэгтэй юмуу эрэгтэй хэлмэрч байлгахыг хичээх болно.

Хэрэв би өвдөөл юу хийх ёстой вэ?

Хэрэв та өвдсөн бол ДүрвэгсдийнАжил байгууллагын ажилтанд юм уу ИНД-ийн ажилтанд хэл. Хэрэв та халдварт өвчтэй бол эсвэл халдварт өвчтэй байх магадлалтай гэж бодож байвал үүнийгээ хэлэх тань илүү чухал. Жич: сүрье, хамуу/маажуур юм уу гепатит В Мөн та жирэмсэн бол ДүрвэгсдийнАжил байгууллагын ажилтанд юм уу ИНД-ийн ажилтанд хэл. Таны сувилагчид хэлсэн бүх зүйлсийг нууцлан хадгалдаг. Сувилагч таны өгсөн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг таны зөвшөөрөлгүйгээр бусдад өгдөггүй. Хэрэв таны дүрвэгсдийн процедур тань явагдаж байх үеэр та өвдсөн бол үүнийгээ ДүрвэгсдийнАжил

байгууллагын юм уу ИНД-ийн мөн СОА-гийн ажилтаны аль нэгэнд хэл. Тэд нар танд зохих (эмнэлгийн) тусламж авахад тань туслана. Хэрэв та ИНД-тэй юм уу өмгөөлөгчтэйгээ ярилцах тэр өдрөө өвдсөн бол СОА-гийн ажилтанд хандан ИНД болон өмгөөлөгчид тань дамжуулж өгөөч гэж хүсэх хэрэгтэй.

Би сайн дураараа нутагруугаа буцаж явахыг хүсч байна.

Хэрвээ та сайн дураараа эх орондоо буцах хүсэлтэй бол Олон Улсын Дүрвэгсдийн байгууллагатай холбогдож болно (ИОМ). Хэрвээ та таны байгаа газартай ойрхон энэ байгууллагын төвд цаг авч уулзахыг хүсвэл: 088 746 44 66 утсаар юмуу энэ хаягт: www.iom-nederland.nl хандаж болно. ИОМ таныг буцахад тусалж мэдээлэл өгч чадна.

Та бас DT&V байгууллагад хандаж мэдээлэл авч болно. Таны дүрвэгсдийн процедур дууссан ч та Дүрвэгсдийн Ажил байгууллагатай холбогдож мэдээлэл асуух болон тусламж хүсч болно. Та аюулгүй улс орноос ирсэн ба өөрийн санаачлагаараа эх орондоо буцахыг хүсч байна уу? Энэ тохиолдолд та орогнох өргөдлөө буцаан татан авсан ч танд буцах тусламжийн мөнгийг олгохгүй. Хэрэв та аюулгүй улс орон луу буцаж байвал ихэнх тохиолдолд танд буцах мөнгө өгдөггүй. Та дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлөө сайн дураараа буцааж татан авсан ч гэсэн танд буцах мөнгө өгдөггүй.

Би нутагтаа буцахыг хүсэж байна. Паспортоо би хэрхэн буцаан авах вэ?

Хэрвээ та аялал ба эсвэл иргэний үнэмлэх болон бичиг баримтуудаа буцахын тулд авахыг хүсвэл DT&V-д мэдэгдэх ёстой шүү. DT&V нь ИНД-гээс бичиг баримтыг буцаах талаар асууна. ИНД таны бичиг баримтыг DT&V-рүү илгээдэг. Яг таныг буцах үед бичиг баримтуудыг тань буцаан өгдөг. Зөвхөн жинхэнэ нь тогтоогдсон аялал- болон иргэний бичиг баримтуудыг л танд буцаан өгдөг.

Тайван байдлыг алдагдуулсан дүрвэгсдэд ямар арга хэмжээ авах вэ?

Нидерландын засгийн газраас танаас болон бусад гадаадын иргэдээс биеэ зөв зохистой авч явахыг хүсдэг. Та дүрвэгсдийн процедурын үедээ болон дараа нь дүрвэгсдийн байранд эсвэл эргэн тойронд нь эмх замбараагүй байдал үүсгэж ямар нэгэн хүндрэл учруулсан уу? Энэ үед танд яаралтай арга хэмжээ авна гэдгийг санах хэрэгтэй. Үүнд дараахь зүйлс багтаана: Тодорхой газарт нэвтрэх хориг тогтоох эсвэл гадаадын иргэдийн хорих байранд таныг хүргэх боломжтой. Түүнчлэн танд шоронд хорих ял шийтгэл оноох боломжтой.

Танд энхүү нийтлэлийг уншсаны дараа энэ явцын талаар өөр асуух асуултууд байна уу?

Тэгвэл та энэ асуултуудаа ИНД-ийн ажилтанд юм уу Дүрвэгсдийн Ажил байгууллагын ажилтнуудад болон өмгөөлөгчдөө тавьж болно.

Та гомдолтой байна уу?

Бүх дүрвэгсдийн процедуртай холбоотой ажилладаг байгууллууд мэргэжлийн түвшинд, хянамгай ажилладаг. Хэрвээ та үнэхээр ямар нэгэн байгууллага танд муугаар хандсан гэж үзэж байгаа бол, гомдол мэдүүлж болно. Таны өмгөөлөгч юмуу VluchtelingenWerk- (Дүрвэгсдийн ажил) байгууллагын ажилтан танд туслах болно.

Энэ нийтлэл нь хамтарсан хэвлэл юм:

Дүрвэгсдийг хүлээн авах төв | www.coa.nl
Эх оронд нь буцаах алба | www.dienstterugkeerenvertrek.nl
Дүрвэгсдийн ба иргэншлэлийн алба | www.ind.nl
Эрх зүйн зөвөлгөө өгөх газар | www.rvr.org
Нидерланд дахь Дүрвэгсдийн Ажил байгууллага | www.vluchtelingenwerk.nl

Даалгавраар бичигдэв.

Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яам, Дүрвэгсдийн асуудал хариуцсан захиргааны www.rijksoverheid.nl

Танд энэ нийтлэлийн агуулгыг өөрчлөх ямар ч эрх мэдэл байхгүй болно. Хэрэв орчуулгаас үүдэн тайлбарт өөрчлөлт орсон тохиолдолд Дүрвэгсдийн Ажил хувилбар нь хүчинтэйд тооцогдоно.